ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДГА-2024/87/НА-СТА-ТШ3**


Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2024 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 261665, 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор/аудитор: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com
Интакс Эксперт Ди Си ХХК-ийн захирал: Д.Сайнжаргал
Утас: 99080493 Цахим хаяг: info.iedca@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/210

танай________-ны №__________-т

ЗҮҮНБАЯН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Ц.БОЛОРМАА ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Зүүнбаян сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Зүүнбаян сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

## Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2023 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангаж, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Үлдэх өртөггүй 60 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6-р сарын 18 өдрийн Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7.1 дэх заалтыг зөрчсөн байна.

01000045

Хөрөнгө зарцуулах тухай 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, 2 тушаал хугацаа хоцроож байршуулсан байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалтыг тус тус зөрчиж байна.

Иргэдэд үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байгаа нь ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

И-баримт-ын системд 14 ширхэг 9,8 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байгаа нь НББ-ийн тухай хуулийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон... бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтыг тус тус зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний 5 үзүүлэлтэд арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 87.0 хувийн биелэлттэй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т. ГАН-ӨЛЗИЙ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **278,083,815.63** | **215,723,548.15** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **123,948,083.06** | **75,261,928.73** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **123,948,083.06** | **75,261,928.73** |
| **31210** | **Төгрөг** | **123,948,083.06** | **75,261,928.73** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 123,948,083.06 | 75,261,928.73 |
| **33** | **АВЛАГА** | **7,920,920.00** | **9,191,365.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 7,920,920.00 | 0 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 0 | 9,191,365.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **146,214,812.57** | **131,270,254.42** |
| **35100** | **Түүхий эд материал** | **91,849,558.11** | **76,461,994.26** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 0 | 0 |
| 35130 | Эм боох материал | 91,849,558.11 | 76,461,994.26 |
| **35400** | **Хангамжийн материал** | **54,365,254.46** | **54,808,260.16** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,364,900.00 | 3,069,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,478,616.36 | 31,263,466.36 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,534,401.00 | 3,303,988.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 0 | 0 |
| 35460 | Хүнсний материал | 5,541,285.10 | 5,330,533.80 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,446,052.00 | 11,840,972.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,003,315,786.40** | **900,643,105.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,003,315,786.40** | **900,643,105.17** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **737,633,265.53** | **635,455,354.93** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 562,451,412.90 | 562,451,412.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -105,650,688.24 | -143,717,775.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 141,500,000.00 | 91,500,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -41,745,833.28 | -50,312,499.90 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 219,558,909.85 | 235,268,488.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -75,192,705.49 | -102,341,749.18 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 64,462,627.00 | 77,055,627.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -28,051,182.21 | -34,944,574.62 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,005,500.00 | 1,005,500.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -993,875.00 | -1,003,175.00 |
| 39217 | Ном | 289,100.00 | 494,100.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **265,682,520.87** | **265,187,750.24** |
| 39301 | Програм хангамж | 2,387,000.00 | 2,387,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,460,479.13 | -1,955,249.76 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 264,756,000.00 | 264,756,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,281,399,602.03** | **1,116,366,653.32** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,281,399,602.03** | **1,116,366,653.32** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,281,399,602.03** | **1,116,366,653.32** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 671,513,673.50 | 671,513,673.50 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 671,513,673.50 | 671,513,673.50 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **396,159,017.81** | **231,126,069.10** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -687,280,153.42 | 396,159,017.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,083,439,171.23 | -165,032,948.71 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 213,726,910.72 | 213,726,910.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,281,399,602.03** | **1,116,366,653.32** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,710,177,620.38** | **622,127,219.54** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,008,604,793.78** | **29,637,071.66** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,008,604,793.78** | **29,637,071.66** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **10,849,015.00** | **6,642,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 10,849,015.00 | 6,642,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 861,437,494.10 | 7,259,979.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 136,318,284.68 | 15,735,092.66 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **701,572,826.60** | **592,490,147.88** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **125,377,406.60** | **71,017,167.12** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 125,377,406.60 | 71,017,167.12 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **576,195,420.00** | **521,472,980.76** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 576,195,420.00 | 521,472,980.76 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **626,738,449.15** | **740,493,501.61** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **626,738,449.15** | **740,493,501.61** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **625,298,449.15** | **738,363,501.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **305,749,262.99** | **384,794,895.38** |
| 210101 | Үндсэн цалин | 174,989,162.00 | 211,614,809.66 |
| 210102 | Нэмэгдэл | 108,520,485.99 | 140,152,000.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,643,055.00 | 9,240,000.00 |
| 210104 | Урамшуулал | 18,596,560.00 | 23,788,085.32 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **37,233,778.25** | **48,263,387.71** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,450,837.80 | 33,368,187.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,948,859.96 | 3,723,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,355,707.91 | 2,979,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 588,952.05 | 744,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,889,420.53 | 7,447,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **58,651,758.60** | **66,223,467.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,223,246.60 | 4,244,031.12 |
| 210302 | Түлш, халаалт | 50,050,000.00 | 56,787,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,378,512.00 | 5,191,936.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **43,430,838.00** | **31,107,416.53** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,641,450.00 | 4,129,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,355,764.00 | 13,113,286.53 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,970,600.00 | 2,665,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,560,000.00 | 1,415,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,658,895.00 | 9,784,330.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 12,862,600.00 | 0.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 381,529.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **101,063,136.61** | **88,751,403.28** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 89,463,498.91 | 75,062,291.98 |
| 210502 | Хоол, хүнс | 11,599,637.70 | 13,689,111.30 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **8,296,285.00** | **4,972,400.00** |
| 210604 | Урсгал засвар | 8,296,285.00 | 4,972,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,928,400.00** | **1,995,400.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,928,400.00 | 1,995,400.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,180,419.00** | **27,691,538.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,948,700.00 | 25,848,640.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 360,000.00 | 213,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 163,777.00 | 200,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,178.00 | 91,684.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 617,764.00 | 617,764.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **64,764,570.70** | **84,563,593.59** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 868,000.00 | 50,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 63,896,570.70 | 84,513,593.59 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,440,000.00** | **2,130,000.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **0.00** | **0.00** |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,440,000.00** | **2,130,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,440,000.00 | 2,130,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,083,439,171.23** | **-118,366,282.07** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0.00** | **46,666,666.64** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 0.00 | 46,666,666.64 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **1,083,439,171.23** | **-165,032,948.71** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

4417144353
ЕЮА0056 9025707

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **902,461,352.40** | **597,861,702.88** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,101,945.80** | **6,642,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **46,101,945.80** | **6,642,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **46,101,945.80** | **6,642,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 27,486,558.35 | 6,642,000.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | 18,615,387.45 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **856,359,406.60** | **591,219,702.88** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **125,377,406.60** | **71,017,167.12** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 125,377,406.60 | 71,017,167.12 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **730,982,000.00** | **520,202,535.76** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 730,982,000.00 | 520,202,535.76 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **572,738,406.34** | **625,300,257.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **572,738,406.34** | **625,300,257.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **571,298,406.34** | **622,155,257.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **305,749,262.99** | **384,191,285.38** |
| 210101 | Үндсэн цалин | 174,989,162.00 | 211,011,199.66 |
| 210102 | Нэмэгдэл | 108,520,485.99 | 140,152,000.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,643,055.00 | 9,240,000.00 |
| 210104 | Урамшуулал | 18,596,560.00 | 23,788,085.32 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **37,233,778.25** | **48,263,387.71** |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,450,837.80 | 33,368,187.71 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,948,859.96 | 3,723,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,355,707.91 | 2,979,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 588,952.05 | 744,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,889,420.53 | 7,447,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **58,651,758.60** | **66,223,467.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,223,246.60 | 4,244,031.12 |
| 210302 | Түлш, халаалт | 50,050,000.00 | 56,787,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,378,512.00 | 5,191,936.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **36,687,000.00** | **21,311,100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,139,700.00 | 3,151,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,823,800.00 | 9,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,087,600.00 | 2,690,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,560,000.00 | 1,490,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,075,900.00 | 4,979,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **87,891,972.50** | **51,573,877.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,792,082.50 | 38,293,477.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,399,890.00 | 11,282,400.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,700,000.00 | 1,998,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **33,581,785.00** | **15,398,180.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,259,400.00 | 341,000.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,833,300.00 | 4,950,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,489,085.00 | 10,107,180.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,928,400.00** | **1,995,400.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,928,400.00 | 1,995,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,149,019.00** | **28,302,538.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,117,300.00 | 25,859,640.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 360,000.00 | 213,450.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 163,777.00 | 200,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,178.00 | 91,684.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 617,764.00 | 617,764.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 800,000.00 | 600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,425,430.00** | **4,896,022.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,425,430.00 | 4,896,022.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,440,000.00** | **3,145,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,440,000.00** | **3,145,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,440,000.00 | 3,145,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **329,722,946.06** | **-27,438,554.33** |

| | | | |
|---|---|---|---|
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **205,774,863.00** | **21,247,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **205,774,863.00** | **21,247,600.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **205,774,863.00** | **21,247,600.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 205,774,863.00 | 21,247,600.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-205,774,863.00** | **-21,247,600.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **123,948,083.06** | **-48,686,154.33** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 123,948,083.06 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 123,948,083.06 | 75,261,928.73 |

4417144353
ЕЮА0056 9025787

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 671,513,673.50 | 213,726,910.72 | -687,280,153.42 | 197,960,430.80 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 671,513,673.50 | 213,726,910.72 | -687,280,153.42 | 197,960,430.80 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | 0.00 | 0.00 | 1,083,439,171.23 | 1,083,439,171.23 |
| **10** | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 671,513,673.50 | 213,726,910.72 | 396,159,017.81 | 1,281,399,602.03 |
| **11** | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 671,513,673.50 | 213,726,910.72 | 396,159,017.81 | 1,281,399,602.03 |
| **13** | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 671,513,673.50 | 213,726,910.72 | 396,159,017.81 | 1,281,399,602.03 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -165,032,948.71 | -165,032,948.71 |
| **20** | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 671,513,673.50 | 213,726,910.72 | 231,126,069.10 | 1,116,366,653.32 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **663,316,000.00** | **577,906,931.09** | 85,409,068.91 | 87.12 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **663,316,000.00** | **577,906,931.09** | 85,409,068.91 | 87.12 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **660,316,000.00** | **576,761,931.09** | 83,554,068.91 | 87.35 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **437,624,100.00** | **388,567,526.38** | 49,056,573.62 | 88.79 |
| 210101 | Үндсэн цалин | 257,901,200.00 | 215,387,440.66 | 42,513,759.34 | 83.52 |
| 210102 | Нэмэгдэл | 144,159,900.00 | 140,152,000.40 | 4,007,899.60 | 97.22 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,717,000.00 | 9,240,000.00 | 2,477,000.00 | 78.86 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 23,846,000.00 | 23,788,085.32 | 57,914.68 | 99.76 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **51,432,600.00** | **48,263,387.71** | 3,169,212.29 | 93.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,537,400.00 | 33,368,187.71 | 3,169,212.29 | 91.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,723,900.00 | 3,723,900.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,979,200.00 | 2,979,200.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 744,400.00 | 744,400.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,447,700.00 | 7,447,700.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **25,998,500.00** | **21,516,100.00** | 4,482,400.00 | 82.76 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,950,000.00 | 3,151,700.00 | 798,300.00 | 79.79 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,596,000.00 | 9,000,000.00 | 1,596,000.00 | 84.94 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,690,000.00 | 2,690,000.00 | 0.00 | 100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 205,000.00 | 205,000.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,857,500.00 | 1,490,000.00 | 367,500.00 | 80.22 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,700,000.00 | 4,979,400.00 | 1,720,600.00 | 74.32 |
| **2105** | **Нормативт зардал** | **53,277,600.00** | **51,573,877.00** | 1,703,723.00 | 96.80 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 38,419,800.00 | 38,293,477.00 | 126,323.00 | 99.67 |
| 210502 | Хоол, хүнс | 12,859,800.00 | 11,282,400.00 | 1,577,400.00 | 87.73 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,998,000.00 | 1,998,000.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **50,399,000.00** | **31,647,080.00** | 18,751,920.00 | 62.79 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,930,600.00 | 19,290,600.00 | 3,640,000.00 | 84.13 |
| 210602 | Тавилга | 3,000,000.00 | 2,093,000.00 | 907,000.00 | 69.77 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,000,000.00 | 4,950,000.00 | 2,050,000.00 | 70.71 |
| 210604 | Урсгал засвар | 17,468,400.00 | 5,313,480.00 | 12,154,920.00 | 30.42 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,300,300.00** | **1,995,400.00** | 1,304,900.00 | 60.46 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,300,300.00 | 1,995,400.00 | 1,304,900.00 | 60.46 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **31,213,300.00** | **28,302,538.00** | 2,910,762.00 | 90.67 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 28,770,000.00 | 25,859,640.00 | 2,910,360.00 | 89.88 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 720,000.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 213,500.00 | 213,450.00 | 50.00 | 99.98 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 91,800.00 | 91,684.00 | 116.00 | 99.87 |
| 210807 | Газрын төлбөр | 618,000.00 | 617,764.00 | 236.00 | 99.96 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 600,000.00 | 600,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **7,070,600.00** | **4,896,022.00** | 2,174,578.00 | 69.24 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,070,600.00 | 4,896,022.00 | 2,174,578.00 | 69.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,000,000.00** | **1,145,000.00** | 1,855,000.00 | 38.17 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,000,000.00** | **1,145,000.00** | 1,855,000.00 | 38.17 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,000,000.00 | 1,145,000.00 | 1,855,000.00 | 38.17 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **663,316,000.00** | **526,844,535.76** | 136,471,464.24 | 79.43 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **563,681,500.00** | **520,202,535.76** | 43,478,964.24 | 92.29 |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 563,681,500.00 | 520,202,535.76 | 43,478,964.24 | 92.29 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **99,634,500.00** | **6,642,000.00** | 92,992,500.00 | 6.67 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,498,000.00 | 6,642,000.00 | -5,144,000.00 | 443.39 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 98,136,500.00 | 0.00 | 98,136,500.00 | 0.00 |

4417144353
ЕЮА0056 9025707

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Төсвийн тохируулга |
|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **75,393,408.12** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **71,017,167.12** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **68,640,926.12** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **68,640,926.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **66,640,926.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **-4,376,241.00** |
| 210101 | Үндсэн цалин | -4,376,241.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **66,223,467.12** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,244,031.12 |
| 210302 | Түлш, халаалт | 56,787,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,191,936.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **4,793,700.00** |
| 210604 | Урсгал засвар | 4,793,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,000,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **6,752,482.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **6,752,482.00** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | -6,752,482.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,694.3 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 10,694.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1.Ахмадын сангийн гүйлгээний тохируулах бичилт 4,376.2 мянган төгрөгөөр алдаатай байсныг НББ-ийн тухай хуулийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулав.

2.Эрүүл мэндийн газрын албан тоотоор үндсэн хөрөнгийн данснаас андуурагдан ирсэн 5,227.3 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг хасч, НББ-ийн тухай хуулийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулав.

3.Эрүүл мэндийн газрын албан тоотыг үндэслэн бараа материалын данснаас андуурагдан ирсэн 449.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг хасч тайланд залруулга хийв. НББ-ийн тухай хуулийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулав.

4.Оны эцсийн тооцоогоор Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 641.7 мянган төгрөгөөр өссөнийг залруулав. НББ-ийн тухай хуулийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулав.

Аудитаар нийт 5 зөрчил илэрснээс 5 зөвлөмж өгсөн

### 5.3 Зөвлөмж

1.Илрүүлэлт:

Үлдэх өртөггүй 60 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй байна.

*Зөвлөмж:*

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 6 р сарын 18 өдрийн Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам 7.1 заалтыг мөрдөж ажиллах;

2.Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай захирлын А тушаалыг, шилэн дансанд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад Хөрөнгө зарцуулах тухай 1 ширхэг тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, 2 тушаал хугацаа хоцроож байршуулсан байна.

*Зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр", дагуу мэдээллийг уг хуулийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн хуулийн заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах;

3.Илрүүлэлт:

Иргэдэд үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн нь санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна.

*Зөвлөмж:*

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ЭМС-ын 2022 оны А/216 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний журам"-ын 3.4-т заасан "И-баримт" заавал олгоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах;

4.Илрүүлэлт:

И-баримтын-ийн системд бүртгэлтэй баримтын жагсаалтыг татан авч сар, өдөр давхардсан, ижил дүнтэй, зөрчилтэй, өндөр дүнтэй, нэг харилцагчаас ПОС болон И баримтын системээс нэгэн зэрэг үүсгэгдсэн зэрэг зөрчилтэй байж болох 29 ширхэг 26 сая төгрөгийн баримтыг түүвэрлэн авч гэрээ, анхан шатны баримт, төлбөрийн баримтууд руу хөөн шалгахад 14 ширхэг 9,8 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байна.

*Зөвлөмж:*

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно, Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна, НӨАТ-ийн тухай хуулийн 17.6 "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон бол татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэж заасан заалтуудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах;

5.Илрүүлэлт:

Өвчтөний ор, Сахиурын сандал, Штативтай сандал, Судас тодруулаг, ЭКГ аппарат, Принтер epson L3258/56 wifi, Принтер /canon pixma G2020 зэрэг үндсэн хөрөнгийг шууд худалдан авалт хийсэн байна.

*Зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно гэсэн заалтыг мөрдөж ажиллах;

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ахмадын сангийн гүйлгээний тохируулах бичилт алдаатай байсныг залруулав. | 1 | 4,376.24 | | | 1 | 4,376.24 | 1 | 4,376.24 | | |
| Эрүүл мэндийн газрын албан тоотоор үндсэн хөрөнгийн данснаас андуурагдан ирсэн үндсэн хөрөнгийг хасаж тайланд залруулга | 1 | 5,227.30 | | | 1 | 5,227.30 | 1 | 5,227.30 | | |
| Эрүүл мэндийн газрын албан тоотыг үндэслэн бараа материалын данснаас андуурагдан ирсэн бараа материалыг хасаж тайланд залруулга хийв. | 1 | 449.00 | | | 1 | 449.00 | 1 | 449.00 | | |
| Оны эцсийн тооцоогоор Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага өссөнийг залруулав. | 1 | 641.75 | | | 1 | 641.75 | 1 | 641.75 | | |
| **ДҮН** | **4** | **10,694.29** | **0** | **-** | **4** | **10,694.29** | **4** | **10,694.29** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үлдэх өртөггүй 60 нэр төрлийн үндсэн хөрөнгөнд бүртгэлийн хяналт тавьж үнэ, болон ашиглах жилийг шинэчлэн бүртгээгүй. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны тухай хуульд заасан хөрөнгө, мөнгө, зарцуулах тухай 1 ширхэг захирлын А тушаалыг шилэн дансанд байршуулаагүй, 2 ширхэг тушаал хугацаа хоцроож байршуулсан байна. | 1 | 1,389.00 | | | | | | 1,389 |
| **Дүн** | **1** | **1,389.00** | | | | | | **1,389.00** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Иргэдэд үзүүлж байгаа төлбөрт үйлчилгээний орлогын цахим төлбөрийн систем дэх И-баримтын дүн санхүүгийн тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Ebarimt- ийн системд 14 ширхэг 9,8 сая төгрөгийн И баримт илүү буюу давтагдсан зөрчилтэй байлаа. | 1 | 9,888.17 | | | | | 1 | 9,888.17 |
| Өвчтөний ор, Сахиурын сандал, Штативтай сандал, Судас тодоруулаг, ЭКГ аппарат, Принтер epson L3258/56 wifi, Принтер /canon pixma G2020 зэрэг үндсэн хөрөнгийг шууд худалдан авалт хийсэн байна. | 1 | 21,042.60 | | | | | 1 | 21,042.60 |
| **ДҮН** | **3** | **30,930.77** | | | | | **3** | **30,930.77** |